



**АХМАДЫН ХОТХОН-1 ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын 2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Зорилт батлах тухай” А/258 дугаар захирамжийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд байгуулсан үр дүн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан өөрийн хөрөнгөөр санхүүжин харьцуулалтын хэлбэрээр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Г.Чулуунбаатар - Дулааны инженер

Гишүүд:

Б.Батаа - Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн төлөөлөл хариуцсан мэргэжилтэн / зөвшилцсөнөөр/

С.Баяржаргал - Нягтлан бодогч

Нарийн бичиг:

Г.Баатархүү - Гэрээний мэргэжилтэн

3. “Ахмадын хотхон-1” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2015 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулж, дүгнэлт шийдвэр гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Г.Чулуунбаатар/-д үүрэг болгосугай.

